

## **“СҮРЬЕЭ БОЛОН ЯМ ӨВЧНИЙ ХЯНАЛТ” САТРЕПС ХАМТАРСАН ТӨСӨЛ**

### **Монгол-Япон улсын Засгийн газар хоорондын хамтарсан төсөл**

Япон улсын Засгийн газар, Монгол улсын Засгийн газар хооронд 2020 оны 1 сарын 16-ны өдөр солилцсон Техникийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд “Сүрьеэ болон ям өвчний хяналт” төсөл хэрэгжиж байна. Хоёр тал төслийн хэрэгжилтийг ЖАЙКА-тай хамтран хариуцаж, бусад холбогдох байгууллагуудтай уялдуулан, төслийн бие даасан үйл ажиллагааг хэрэгжүүлж байх хугацаанд болон хэрэгжүүлсний дараа тогтвортой байлгаж, Монгол Улсын эдийн засгийн хөгжил болон нийгмийн амьдралд хувь нэмэр оруулахаар хоёр тал тохиролцсон.

#### **Санхүүжүүлэгч:**

Япон талаас: Японы олон улсын ЖАЙКА байгууллага, Эрүүл мэндийн судалгаа, хөгжлийн байгууллагын хамтарсан "Тогтвортой хөгжлийн төлөө шинжлэх ухаан, технологийн судалгааны түншлэл" (САТРЕПС)-ийн хүрээнд халдварт өвчний чиглэлээр 2020—2025 онд “Сүрьеэ болон ям өвчний хяналт” төслийг санхүүжүүлж байна.

#### **Хэрэгжих хугацаа**

2020 оны 11 дүгээр сараас 2025 оны 10 сарыг дуустал хэрэгжинэ.

#### **Төслийг хэрэгжүүлэгч байгууллагууд:**

Төслийг Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Мал эмнэлгийн хүрээлэн, Япон улсын Хоккайдогийн их сургууль, Япон улсын сүрьеэ судлалын хүрээлэн хамтран хэрэгжүүлж байна. Монгол улсын БШУЯ, Сангийн яам, Мал эмнэлгийн ерөнхий газар, Зоонозын өвчин судлалын үндэсний төв уг төслийг дэмжин, хамтран ажиллаж ирсэн.

#### **Төслийн зорилго:**

Сүрьеэ, ям өвчнийг нэг эрүүл мэнд үзэл баримтлалд тулгуурлан, шинжлэх ухааны үндэслэлтэй хянах тогтолцоог Монгол Улсад бүрдүүлэх

#### **Төслийн хүрэх үр дүн**

1. Халдварт зооноз өвчнийг оношлох шинэ техник, технологид суурилсан түргэвчилсэн оношлуурыг Япон эрдэмтэд зохион бүтээж үхрийн сүрьеэ болон адууны ямын халдварыг илрүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх замаар Монгол Улсад одоогийн хэрэглэгдэж байгаа сүрьеэ, ям өвчнийг оношлох аргыг шинэчилж зоонозын өвчний оношилгоог сайжруулна..
2. Адууны ям, үхрийн сүрьеэ зэрэг зоонозын халдварын эрсдэлийн үнэлгээ хийж, бодит нөхцөл байдлыг тодорхойлно.
3. Адууны ям, үхрийн сүрьеэ зэрэг зооноз өвчний тархалт, халдварлалтын бодит нөхцөл байдлыг ийлдэс судлал,молекул биологийн аргаар тогтооно.

4. Нэг эрүүл мэнд (One health) үзэл баримтлалд тулгуурласан зооноз халдварт өвчнийг хянах платформыг бий болгоно.

### **Монгол улсад төслийн зүгээс ирэх бодит үр өгөөж**

- Монгол улсын мал эмнэлгийн салбарт Био-аюулгүй байдлын 3-р зэрэглэлийн иж бүрэн лаборатори байгуулах, хүн эмнэлэг түүний дотор сүрьеэгийн салбарт орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмж бүхий халдварт өвчний үүсгэгчийн геномийн бүрэн дараалал тогтоох лабораторийг байгуулаад байна
- Хүн, мал эмнэлгийн салбарын 20 орчим мэргэжилтэн, судлаачдыг Япон улсад урт богино хугацааны сургалтад хамруулан боловсон хүчний чадавхийг дээшлүүлээд байна.
- Оношилгооны дэвшилтэт технологи, багаж төхөөрөмжийг суурилуулах, үйл ажиллагааг жигдрүүлэх, улмаар нутагшуулахад техникийн туслалцаа үзүүлж байна.
- Япон улсын профессор, эмч, мэргэжилтнүүд зоонозын өвчний чиглэлээр Монгол судлаачидтай хамтарсан судалгааг гүйцэтгэж салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлж байна.

### **Төслийн Хамтарсан Зохицуулах Хороо**

Төслийг Эрүүл Мэндийн Яам (ЭМЯ) ахалж, Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ), Мал эмнэлгийн ерөнхий газар (МЭЕГ) хамтран хэрэгжүүлж байна.

Төслийн хэрэгжилтийн хугацаанд Хамтарсан Зохицуулах Хорооны хурлыг 4 дөх удаагаа хамтран зохион байгуулж, төслийн үйл ажиллагааны хэрэгжилт, тулгамдаж буй асуудлуудын талаар санал солилцож цаашдын гарц гаргалгааг шийдвэрлэн өнөөдрийг хүртэл төслийн үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлж ирлээ.

### **Эрдэм шинжилгээний олон улсын хурал**

Төслийг хэрэгжүүлэгч Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Мал эмнэлгийн хүрээлэн, Япон улсын Хоккайдогойн их сургууль, Япон улсын сүрьеэ судлалын хүрээлэнгийн эрдэмтэн судлаачид Сүрьеэ болон ям өвчний хяналт” төслийг хэрэгжүүлэх явцад гарсан үр дүнгүүдээр